

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/06/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2024/06/НА-СТА-ТШЗ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.05, № 18

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улаанбаатар хотод зохион байгуулсан шүүгчдийн нэгдсэн 2 дугаар чуулган, шүүхийн захиргааны ажилтны "Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого" хэлэлцүүлэгт шүүгчид болон албан хаагчид оролцсон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 11,999.5 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй 78,238.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 21,470.6 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж биелэлтийг 90.94 хувиар үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07020405

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,193.2	43,710.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	792,287.6	843,513.4
	Нийт хөрөнгийн дүн	819,480.8	887,223.5
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	819,480.8	887,223.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	819,480.8	887,223.5
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,362,449.3	1,817,851.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,388,002.7	1,750,108.7
	Үйл ажиллагааны үр дүн	(25,553.5)	67,742.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(25,553.5)	67,742.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	845,034.3	819,480.8
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
	Тайлант оны үр дүн	(25,553.5)	67,742.7
	Эцсийн үлдэгдэл	819,480.8	887,223.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,327,398.3	1,711,457.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,314,809.3	1,691,303.6
	Үйл ажиллагааны ЦМГ	12,589.0	20,153.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(9,449.0)	(11,999.5)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	3,140.0	8,154.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,140.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,140.0	3,148.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,296,622.6	1,676,266.1
	Урсгал зардал	1,296,622.6	1,676,266.1
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,296,622.6	1,676,266.1
	Улсын төсвөөс санхүүжих	1,296,622.6	1,676,266.1
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 608.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Хуультай холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 608.9 мянган төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 2,895.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 2,895.4 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрч зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 2 албан шаардлага өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Говь-Алтай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 112/ШЗ2022/0085 дугаартай шүүгчийн захирамжаар шинжээчийн зардлыг Экоплант ХХК хариуцахаар заасан байна. Гэтэл Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтний хувийн дансанд 1,890.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Говь-Алтай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 112/ШЗ2022/0085 дугаартай шүүгчийн захирамжийн 4-т "Экоплант ХХК-ийн Y-0506000007, Y-0506000006, дугаар бүхий газар зохион байгуулалттай 750 ам², га нийт 1500ам² га газарт байрлах услалтын системийн байгууламж, Экоплант ХХК-ийн газрын кадастрын зурагтай холбоотой шинжээчийн зардлыг Экоплант ХХК хариуцах болохыг дурдсугай" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шинжээчийн зардлыг хариуцах этгээдээр төлүүлэх арга хэмжээг авч ажиллах.

2. Урсгал засварын зардлын төсвөөс эдийн засгийн ангилал зөрчиж 1,005.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" Урсгал засварын зардал: Байгууллага өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар үйлчилгээний хөлс энэ ангилалд хамаарна. Тус бүлгийн зардлуудыг эдийн засгийн ангилал тус бүрээр хянаана.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газар	Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөр 608.9 мянган төгрөгийг татварын нэвтрэлтийн нэгдсэн системд дутуу шивсэн байна.	1	608.9	1	608.9			1	608.9		-	-	-
Дүн		1	608.9	1	608.9			1	608.9			-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагы н нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
											Тоо
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газар	Говь-Алтай аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 112/ШЗ2022/0085 дугаартай шүүгчийн захирамжаар шинжээчийн зардлыг Экоплант ХХК хариуцахаар заасан байна. Гэтэл Газрын харилцаа, барилга хот байгууллалтын газрын мэргэжилтний хувийн дансанд 1,890.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн байна.	1	1,890.0			1	1,890.0		-	-	-
	Урсгал засварын зардлын төсвөөс зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 1,005.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн.	1	1,005.4			1	1,005.0		-	-	-
	Дүн	2	2,895.4			2	2,895.4		-	-	-